



А.Цог-Очир  
МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, шинжлэлийн тэнхимийн багш,  
профессор

## “УУР” (ХИЛЭН) ХЭМЭЭХ УХАГДАХУУНЫ КОНЦЕПТУАЛ БҮТЭЦ

**Abstract:** This research article discusses that the Mongolian concepts behind the metaphors “uur” (anger) and “uur” (steam) are the same. Also, it has shown that the extensional meaning of verbs and the source domains of metaphorical expressions. The source domains of metaphorical expressions of the concept “uur” (anger) in both Mongolian and Korean are similar. It seems common in both languages and cultures. We have proposed the idea of looking at the modern concept of Cognitive semantics theory in connection with the method of explaining similes, metaphors, and means of poetic expressions in The Dandin’s “Kvydarsha.”

**Түлхүүр үг:** уур, концептуал, метафор

Хэл бол хүний ухамсарт үйл ажиллагааг илэрхийлэх арга төдийгүй түүх-соёлын туршлага хийгээд мэдлэг эзэмших, хадгалах, дамжуулах хэрэглүүр, басхүү ертөнцийг танин мэдэхүйн хүчирхэг хэрэгсэл юм. Хэл бол сэтгэлгээний хэлбэр төдий бус, басхүү соёлын чухал элемент учраас хэл, сэтгэлгээ, соёл гурвын хооронд нэг нь нөгөөгүйгээр байж үл болох жам ёсны, салшгүй холбоо байдаг.

Хэл нь нийгмийн амьдралын тусгал учраас тухайн нийгмийн бүх соёл хэлэнд хамаатай, тиймээс хэл нь тухайн хэлний үндэс суурь болох соёл, хүн-нийгмийн харилцааны бүх талыг тусгаж ‘ертөнцийн хэлний зураг’ бүтээх дохио тэмдгийн тогтолцоо болдог байна.

Ертөнцийн хэрэг явдлыг таньж ухаарсан хүн төрөлхтний мэдлэгийн сан нь хоёр гол түвшинд, үүнд нэгдүгээрт, хэлэнд, тодруулбал, хэлзүй ба үгийн сангийн утгазүйн тогтолцоонд, хоёрдугаарт, хэлэхүйд буюу аман ба бичгийн харилцаанд тус тус хадгалагдан үлддэг байна. В. Фон Гумбольдт “Хэл бол үндэсний оюун санааны илэрхийлэл, сэтгэлгээ ба гадаад ертөнцийн

хоорондох завсрын ертөнц” хэмээн тодорхойлсон байдаг. Чухамхүү хэлэнд ард түмний танин мэдэхүйн бүхий л туршлага, шашин-гүн ухааны, зан суртахуун-ёс зүйн, нийгэм-хүмүүжлийн, уран сайхан-гоозүйн төсөөлөл болон зарчмууд хэрэгжсэн байдаг. Иймээс хэл бол угсаатан-соёлын үйл ажиллагааны тулгуур элемент болно, бас тухайн үндэстэн, угсаатны нийгмийн ухамсар, уламжлал ба соёлыг хадгалах, нэвтрүүлэн дамжуулах арга болно.

Үгийн утга хэрэглээний нарийн ялгааг илтгэж буй хам хүрээллийн доторх үг хэллэг бүрийн цаана ард түмний аж төрөх хэв маяг нь ертөнцийг үзэх үзлийн төсөөлөл, үнэт зүйлийн баримжаа, сэтгэлзүйн шинж байдал, үндэстний өвөрмөц онцлог, ёс заншил, уламжлалын хамт ил ба далд байдлаар оршиж байдаг ажээ.

Хүрээлэн буй ертөнцийг үг хэллэгээр дамжуулан ойлгож ухаарах арга зам нь тухайн ард түмний аж төрөх аргын онцлог, нийгмийн ухамсрын байдал, газарзүйн онцлог, түүх соёлын ялгаа, зан үйл, утга соёлоос хамаарч өөр өөр байдаг. Иймээс тухайн хэлийг бүтээж, түүгээр хэлэлцэгч ард түмэн бүр нийгэмшихүйн явцад ертөнцийн өөрийн гэсэн өвөрмөц хэлний зургийг бүтээж байдаг. Ертөнцийн хэлний зураг дахь үг бүхэн тухайн юм, үзэгдлийг өөрийг нь бус, харин хүний ухамсарт энэхүү юм, үзэгдлийн тухай ойлголт, төсөөллөөр төрөгдөж буй хийсвэр зүйлийг тусгадаг хэмээсэн үзэл буй. Тодруулбал, хэл бол ертөнцийг бус, харин энэхүү ертөнцийг төсөөлөх аргыг тусгадаг хэмээн үзсэн нь ч буй. Ертөнцийг үзэх үзэл нь танин мэдэхүйн аргыг тодорхойлдог бол ертөнцийн зураг нь танин мэдэхүйн үр дүн болох ажээ. Тэгвэл ертөнцийн хэлний зураг гэдэг нь хөгжлийн тодорхой үед бодит байдлын тухай хэлний нэгжүүдэд тэмдэглэгдсэн, ард түмний төсөөллийн нийдэм цогц, ертөнцийг хэлээр хэсэглэхүй буюу хэлний тэмдгүүдийн утгад туссан бодит байдлын тухай



төсөөлөл, юмс үзэгдлийг хэлээр эмхлэхүй байдал, үг хэллэгийн тогтолцоот утгуудад суусан ертөнцийн тухай мэдээлэл [5:54] болох ажээ.

Метафор бол тухайн ойлголт ухагдахуунд ард түмэн хэрхэн хандаж ирсэн түүхэн төсөөллүүдийг тусгадаг учраас концептыг тодорхойлон бичихэд онцгой учир холбогдолтой болж байна. Концепт бол (латин хэлний *conceptus* хэмээх үгээс гаралтай аж.) хувь хүн ба нийгмийн танин мэдэх үйл ажиллагааны үр дүн, тусган илэрхийлж буй юмс үзэгдлийн тухай багцармал, суурь мэдээллийг агуулж буй үндэсний сэтгэлгээний нэгж, угсаатан-соёлын онцлогийг тусгасан хийсвэр нэгж болно. Харин үндэсний сэтгэлгээ гэдгийг тухайн үндэстний танин мэдэхүйн тогтсон хэв маягуудын нийдэм цогцоор тодорхойлогдож буй, бодит байдлыг ухаарч, ойлгож мэдэх үндэсний арга хэмээн үздэг байна.

Америкийн эрдэмтэд метафор бол бидний өдөр тутмын харилцаанд 'нэвчсэн' байдаг учраас ердийн ухагдахууны тогтолцоо нь бидний сэтгэж, үйлдэж буй хүрээнд метафорлог шинжтэй юм. Нийтээр дагаж заншсан концептуал метафорын тогтолцоо нь ухамсарлагдахгүй, тиймээс өдөр тутмын ердийн үйл ажиллагаанд нэгэнт хэвшсэн тодорхой загварын дагуу юм бүхнийг ямар ч хүчлэлгүй хар аяндаа бодож үйлддэг хэмээн үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, бид амьдрал ахуйдаа гүн нэвчсэн метафор тогтолцоонд оршин амьдарч байгаа юм гэж үзэж байна<sup>1</sup>. Ингэхлээр концептуал метафорын мөн чанар нь нэг төрлийн үзэгдлийг өөр нэг төрлийн үзэгдлийн концептуал тогтолцоонд оруулж ухаарахад оршиж байна. Концептуал метафорууд нь үнэт зүйлсийн нийтээр заншсан тогтолцооны хүрээнд үүсэж, тухайн нийгмийн ойлголт, ухамсар, аж төрөхүйн ёсны уламжлалд тулгуурладаг байна.

Концептуал метафор нь соёлын загварын мөн чанарыг бүрэн тодруулахад тус дөхөм болдог төдийгүй нарийн түвэгтэй оюун дүгнэлт болон учир шалтгааны ул мөрийг илрүүлэх үйлдэлтэй байна.

Метафор нь гүнзгий нарийн утга илтгэхээс гадна, ялангуяа, хийсвэрлэх арга болох адилтгал зүйрлэл, төлөөлөл зэргээс бүтэж, энэ хирээр сэтгэлгээний дээд эрэмбийн нэгдэл буюу оюун ухаанд бүрэлдэж буй сэтгэлгээний орон-үйлдлүүдийн шүтэн барилдлагын мөн чанарыг тодорхой илтгэж буй хэл-соёлын нэгж гэж үзэж байна.

Хэлэхүйн үйл ажиллагаа нь хүний аяндаа хийж сурсан нарийн түвэгтэй ментал үйлдлүүдийг агуулж байдаг. Иймээс хүний уураг тархинд буй болдог когнитив үйлдлүүд нь хамгийн энгийн ойлголтоос авхуулаад нарийн түвэгтэй онол хүртэлх янз бүрийн түвшний үйлдлийг бүтээх чадвартай юм.

G. Lakoff нарын боловсруулсан "Концептуал метафорын онол" (Conceptual metaphor theory) нь сурвалж домэйн (source domain), бай домэйн (target domain), буулгалт (mapping) гэсэн сэтгэлгээний буюу мэдээллийн орон, сүлжээнд хийсвэр ойлголт ухагдахуун, туршилтыг тодорхой ойлголт, туршилтаар сэтгэн ухаарах, тогтсон ойлголтуудын харьцааг тайлбарлах, хүний бодол санааны үйлдлийг ойлгоход чиглэсэн хоёр оронтой концептуал загварын онол болно. Хэлний хийсвэрлэх арга болох зүйрлэл, төлөөлөл, утга шилжүүлэх ёс, уран дүрслэлийн эдгээр арга нь когнитив утга судлалын өвөрмөц судлагдахуун болох тул ертөнцийг таньж ухаарсан туршлага, тогтсон соёл, аж төрөхүйн өвөрмөц байдал тэргүүтнээс үүтгэн метафорыг бүтээн хэлж буй оюуны үйл нь сэтгэлгээний ямар шатыг дамжин хийсвэрлэгдэж буйг тайлбарлахад концептуал метафорын онол нэлээд тохиромжтой гэж үзэж байна.

Учир нь хүний амьдралын болон танин мэдэх үйл ажиллагааны явцад ухамсар сэтгэлгээнд бүрэлдэн тогтсон хоёр өөр ухагдахууны далд шинж чанаруудыг зүйрлэн адилтгаж, утгын нарийн холбоогоор хүний дотоод ертөнц, сэтгэл хөдлөлийн өвөрмөц онцлогийг илхнээ болгон ухааруулж илтгэхдээ гадаад ертөнц буюу бодит юмсын онцлогтой холбон зүйрлэсэн сэтгэлгийн үйлдэл нь дээд эрэмбийн хийсвэрлэл, танилт болно. Хэл нь танин мэдэхүйн хэрэглүүр хэмээсний учир чухам үүнд байна.

G. Lakoff & M. Johnson нар 'Бай домайн бол домайнуудын хоорондох метафор холбоог тодорхойлж буй сурвалж домайн' [13:196] гэсэн томъёо ашиглаж, метафор буулгалтыг тайлбарласан байдаг. Буулгалт бол тэгш хэмт бус, учир нь метафор хэллэг нь сурвалж домэйныг биш, харин бай домэйн дахь концептуал бүтцийг дүрслэн харуулдаг байна. Метафор хэллэгүүд бол утгазүйн хоёр домэйний хоорондох концептуал буулгалтын илрэл болно.

Монголын эрдэмтэн Х. Гаадангийн туурвисан "Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл" хэмээх бүтээлд өгүүлснээр адилтгалыг цэгцлэн бүтээдэг гурван зүйл махбодын дотроос адилтгалын үүсвэр болох зүйл нь адилтгаж чадах үг бөгөөд адилтгал биелэхэд чухал үүрэгтэй гэснээс гадна адилтгагдахуун үг, адилтгаж чадах үг хоёр нь харилцан нууц холбоотой гишүүн гэсэн нь сонирхол татаж байна. Үүнд, адилтгалын үүсвэр болох зүйл буюу адилтгаж чадах үг ('үлгэр') гэдэг нь сэтгэлгээний сурвалжийг, адилтгагдахуун буюу 'үлгэрт' гэдэг нь хэлэхүйн зорилго болох бай хүрээ, орныг хэлж байх мэт. Өөр нэг чухал зүйл нь "Жишин үйлдэх үлгэртээ ямар мэт байгаа зүйл нь жишигдэх үлгэртэнд мөн тэр янзаар байгааг нь адилтган тодорхойлж, онон үйлдэх нь үлгэрийн чимэг" [2:70] хэмээсэн нь адилтгалын бэлгэ чанарыг гаргах тухай

<sup>1</sup> G. Lakoff & M. Johnson. *Metaphors We Live By*. 2003

өгүүлсэн хэрэг бөгөөд адилтгалын бэлгэ чанарыг гаргах гэдэг нь когнитив утга судлалын conceptual mapping гэдэгтэй дүйхээр байна. Нөгөө талаар, адилтгагдахуун-адилтахуун, зүйрлэгдэхүүн-зүйрлэхүүн, үлгэр- үлгэрт хоёрыг 'тэгш онолт болгох' буюу адил ухагдахуун болгож байгаа нь өөр өөр зүйлийг учир шалтгаан хийгээд уран санааны үүднээс холбон, адил чанартай болгож байдаг гэж үзсэн зэрэг нь метафорын шинжилгээнд чухал баримтлал болно.

Монгол хэлний тайлбар толь бичгүүдэд 'уур' гэдэг үгийн утгыг дараах байдлаар тайлсан байна. Үүнд:

(1) Я. Цэвэл. "Монгол хэлний товч тайлбар толь"-д:

Уур **I**. Шингэн зүйлийн халахад гарах нойтон хий: усны уур, амны уур, уур манан, уур цан, уурын хүч, уурын тэрэг...уурын хөдөлгүүр (уурын хүчийг механик хүч болгож хувиргах хэрэгсэл): уурын зуух, уурын нүх, уурын угаал хийх (халуун уураар эмчлэх), цаг уур, уур амьсгал (цаг агаарын байдал, цаг уурын мэдээ, дулаан уур амьсгалтай газар)

Уур **II**. Хилэн, ихэд дургүйцэж хорсох байдал; уур хилэн, уур хүрэх, уур бие зовооно, уул морь зовооно.

(2) Ц. Норжин. "Монгол хэлний тайлбар толь"-д:

Сэтгэл санаанд тааламжгүй болсны овор дээрх илрэл.

Уураа дарах- нэгэнт хүрсэн уурыг тэвчээрлэн, өрвөсгөхгүй байх

Уур унтуу – уурласан хүний царайд илрэх бухимдал

Уур уцаар- уурласан хүний хатуу гажуу үгс

Уур нь гарах -уурлахаа зогсох

Уур нь шатах-хилэн өрвөсөж, тэсэшгүй давчдан ад буух

Уур хилэн- бачимдах, хорсох хосолсон илрэл

Уур хөдлөх- тогтуун талбиун байснаа гэнэт уур хүрч эхлэх

Уур төрөх- уур хүрэх

Уур зооглох-уурлахыг дооглох үг, дотроо уурлавч илэрхийлэх аргагүй байдалд орох

Уур **II**. Хатуу төлөвт бодисын алгасан хийжихэд үүссэн хий төлөвт бодис. Усны уурыг заана. (58-р тал)

(3) Сэцэнцогт. "Монгол үгсийн язгуурын толь"-д:

Уур **I**. Шингэн бодисын халахад гарах хий. Усны уур, уур манан. Цаг улирлын хэм.

Уур **II**. Хилэн, догшрох ааш

Хилэн-их уур хорсол. Хэнхдэг дүүрэн хилэн. Хилэнгийн гал тэнгэр тулах. Хилэн төрөх. Зөрчинөөр 'dzili' гэнэ. Өшөө хорслыг Дагураар

'kilen' гэнэ хэмээн тус тус тайлбарласан байна.

Хүний сэтгэл хөдөлж, 'уур хүрэх' гэдэг нь угтаа саван доторх ус халж, уур үүсэх үзэгдэлтэй адил зүйл гэж сэтгэсэн байх бөгөөд үүнийг онцгой содон байдлаар нотлон илэрхийлж байгаа зүйл бол 'усны уур', 'уур хилэн' хоёрыг нэг л үгээр нэрлэн тэмдэглэсний улмаас уур гарах, уур намдах, уураа гаргах, уураа дарах, уур нь дарагдах, бөөн уур, уурандаа дэлбэрэх шахах гэх мэт омоними хэллэгүүд буй болсон нь нэн сонирхолтой бөгөөд хүний сэтгэл хөдлөлийн янз байдлыг бодит юмсын онцлогтой холбон, ил далд шинжээр нь адилтган зүйрлэсэн сэтгэлгийн энэ үйлдэл нь концептуал бүтцийн тодорхой жишээ болж байна.

Монгол хэлний 'уур' гэдэг үг уур **хилэн**, уур **хорсол**, уур **омог**, уур **бухимдал**, уур **уцаар**, уур **унтуу** гэх мэтээр ойролцоо утга бүхий үгстэй хоршиж байгаа байдал нь үнэн хэрэгтээ 'уурлах'-ын ялгаа зэргэмж, их бага хүчдэлийг илтгэж байгаа хэрэг бөгөөд энэ нь шингэн төлөвт бодис халж, уурших үзэгдэл, уурын даралт өсөх, буурахтай утга чанар нэг юм.

Монгол хэлний "уур" хэмээх үндсээс УУРЛА-, УУРШ- гэсэн үйл үг бүтэж байгааг ажиглавал нэг нь хүний сэтгэл хөдлөлийг заасан хийсвэр үйл, нөгөө нь бодит юмын үйл буюу үүсэх буй болохыг заасан утгатай байна.

Хийсвэр юмыг сэтгэлээр мэдрэх юм уу сэтгэлд төрөгдөхийг 'хүрэх' хэмээсэн бөгөөд **уур хүрэх**, **уцаар хүрэх**, **хилэн төрөх** хэмээсэн нь сөрөг мэдрэмж сэтгэлд үүсэх, буй болохыг илтгэж байна. Уур хилэн нь халуун чанартай бол айдас нь хүйтнийг мэдрүүлэх үйлдэлтэй байх тул **айдас хүйдэс** гэсэн хэллэг үүссэн буй заа. Ууртай хүн, ууртай сав (уур бүхий буюу уураар дүүрсэн) хоёр нь концептуал шинжээрээ яв цав тохирч байсны учраас монгол хэлний уур (усны), уур (хилэн) нь омоними буюу дуудлага, бичлэгээрээ ижил үг болсон байна. Хүний дотор сэтгэлд халуун чанартай 'уур' үүсэж, сэтгэл хөдлөх, хямрах, үймрэх, дотор нь давчдах, байж ядах, хөл гар нь салганах, нүүр нь чинэрэх, даралт ихсэх зэрэг янз байдал нь, үнэн хэрэгтээ, савтай ус хэт халж, уурын даралт өссөнөөс үүсэх шинж тэмдэг, физикийн хэлээр "ханасан ба ханаагүй уур" үүсэх үзэгдэлтэй агаар нэгэн зүйл юм. Уур хилэнгийн концептуал бүтцийн мөн чанар үүнд байгаа бөгөөд уурлан хилэгнэхийн 'ямар мэт' шинжийг уурын даралт бүхий савны шинжүүдтэй 'тэгш онолт' болговоос концептуал метафор болох ажээ.

Монгол хэлний УУР (хилэн) хэмээх үгтэй холбогдож буй үйл үгийн утгын агууламжаас үүтгэн, хэлц хэллэгийн сурвалж хүрээг тооцож үзвэл дараах байдалтай байна.



Хүснэгт 1. “УУР”-ын метафор хэллэгийн сурвалж хүрээний жишээ.

№	Сурвалж нь:	Жишээ:
1	<b>уур</b>	уур нь гарах
		уур нь намдах (намжих)
		уураар утах
		дэлбэртлээ уурлах
2	<b>ус</b>	уур нь буцлах
		уур нь дэврэх
3	<b>гал</b>	уур нь шатах
		уурандаа шатах
		уур нь дүрэлзэх
		уур хилэнгийн гал (бадрах)
		уур нь дүрсхийх
4	<b>юм</b>	дүрсхийн уурлах
		бөөн уур
		баахан уур (уцаар)
		уурын тулам
		уураа гаргах
		уураа барах
5	<b>өвчин</b>	Уураа барих
		галзууртлаа уурлах
		үхтлээ уурлах
		ухаан алдталаа уурлах
		уурандаа багтрах
6	<b>дайсан</b>	уураа тэвчих
		уураа дарах
		уураа дийлэх(гүй байх)
7	<b>хоол</b>	уур нь дарагдах
		уур зооглох

Солонгосын эрдэмтэн Им Жи Рён “Суурь сэтгэл хөдлөлийн адилтгалын хэв маягийн судалгаа” хэмээх бүтээлдээ Солонгос хэлний ‘уур’-ын метафор илэрхийллийн сурвалж хүрээг дараах байдлаар судлан тогтоосон байна. Үүнд:

1. Аяганд буй шингэн
2. Эд юм
3. Ургамал
4. Хоол хүнс
5. Дайсан
6. Гал
7. Байгалийн хүч
8. Уяа

Үүнээс үзэхэд, Монгол, Солонгос хэлэнд уурын метафор илэрхийллийн сурвалж хүрээ нь ерөнхийдөө адилавар байгаа нь уурын метафор бол хэл, соёлын нийтлэг шинжтэйг харуулж байгаа юм. Савтай шингэн халж, уурын даралт үүсэх зүй тогтол, хүний биед сэтгэлийн сөрөг хөдөлгөөн үүсэж, даралт ихэсгэдэг энэ зүй тогтлыг хэлэнд тусган илэрхийлж байгаа байдал нь ертөнцийг таньж мэдсэн арга ухаан, үндэстний сэтгэлгээ, соёлын өвөрмөц онцлогийн илрэл болж байна.

Шингэн халах тусам уур үүсэж, савны хананд үзүүлэх даралт өсдөг, улмаар хананы эсэргүүцлийн хязгаарыг давмагц дэлбэрдэг энэ зүй тогтол нь хүний биед сэтгэлийн сөрөг хөдөлгөөн буй болж, уур хилэн нэмэгдэн нэмэгдсээр хяналтаа алдаж, орчин тойрондоо балаг тарьдаг байдалтай агаар нэгэн юм.

Kövecses УУРЛАЖ БУЙ ХҮН БОЛ ДАРАЛТТАЙ САВ гэсэн өвөрмөц метафорыг ялган тодорхойлж, сурвалж ба бай домайны хоорондох буулгалтыг дараах байдлаар нотолсон байна. Үүнд:

Хүснэгт 2. УУРЛАЖ БУЙ ХҮН БОЛ ДАРАЛТТАЙ САВ гэсэн метафор. (Kövecses, 2005, p.39)

Юм агуулсан сав	→	уурлаж буй хүн
Саванд буй юм	→	уур хилэн
Саван дахь юмын даралт	→	хүнд үзүүлж буй уурын нөлөө
Даралтын шалтгаан	→	уурлах шалтгаан
Саванд буй юмыг тогтоох	→	уурыг тэвчиж биеэ барих
Юм савнаас халих	→	уурлаж буйн илрэл

Тогтвортой метафор бол сурвалж ба бай домайны хоорондох концептуал буулгалт бөгөөд онтологи ба эпистемик хоёр төрлийн тохирцыг шаарддаг байна. Үүнийг УУР БОЛ ХАЛЖ БАЙГАА ШИНГЭН /AN-GER IS HEAT OF A FLUID/ гэсэн метафорын жишээгээр дүрслэн харуулбал дараах байдалтай болох ажээ. [13:197]

<b>Онтологи тохирлууд:</b>		
<b>Сурвалж:</b> ХАЛЖ БУЙ ШИНГЭН	<b>Бай:</b>	УУР
Сав		Бие
Шингэн халах		Уур хүрэх
Халууны түвшин		Уурын хэмжээ
Саван дахь даралт		Цусны даралт
Буцалж буй шингэн дэврэх		Түр зуур догдлон үймрэх
Савны эсэргүүцлийн хязгаар		Уураа тэвчих хүний чадварын хязгаар
Дэлбэрэх		Хяналтаа алдах

**Эпистемик тохирлууд:**

Саван дахь шингэн тодорхой хязгаарыг давж халахад даралт нь сав дэлбэрэх хэмжээнд хүртэл өснө.

Дэлбэрвэл савыг эвдэж сүйтгэхээс гадна орчин тойрондоо аюултай.

Дэлбэрэлтийг хангалттай хүч ба даралт эсэргүүцэгч тогтоон барьж байж болно.

Даралтыг хянах замаар дэлбэрэлтийн аюулыг бууруулж болно.

Хүний уур хилэн тодорхой хязгаарыг давахад цусны даралт нь хяналтаа алдах хэмжээнд хүртэл ихэснэ.


Хяналтаа алдвал өөрт төдийгүй бусдад аюултай.

Зоригийн хүчээр уурыг тэвчиж болно.

Уураа тэвчиж баймааж, хал балгүй дарж, тайвширч болно.

Хүний сэтгэл хөдлөлийн сөрөг үйлдэл болох уурлах үйл, түүнийг илэрхийлж буй утгын орны үг хэллэг нь бодит байдалд ус халах, уур үүсэх, улмаар буцлах, дэврэх, даралт үүсгэх, дэлбэрэх зүй тогтолтой яв цав нийцэж байгаа нь концептуал бүтцүүдийн онтологи ба эпистемик тохирлын тодорхой жишээ болно. Уур үүсэхээс дэлбэрэх хүртэлх явц нь халууны хэм нэмэгдэхтэй шууд хамааралтай зүйл бөгөөд хүн уурлахын хэрээр цусны даралт нь ихсэж биеэ барих чадваргүй болж, өөртөө болон бусдад уршиг тарьдаг нь, үлгэрлэвээс, саван доторх уурын даралт ихсэж, ханын эсэргүүцлийг давмагц дэлбэрч, орчин тойрондоо аюул учруулдагтай адил чанартай юм. Өргөн утгаар хэлбэл, байгаль, хүрээлэн буй орчны юмс үзэгдлийн үйл-үрийн мөн чанар, бодит үнэнийг хүний харилцаа, сэтгэл зүрхний хөдлөлтэй харьцуулан адилтгасан нь метафор бол бодит ертөнцийг ухаарч таньсан хүний туршлагаас үүдэлтэй, түүнчлэн хүний үйлдэл хөдөлгөөн, хэрэг явдал, бодол санаа, сэтгэл хөдлөл зэрэг хийсвэр байдлыг бодит ертөнцийн юмс үзэгдлийн буюу материаллаг байдлын үзэл, шинж чанараас хийсвэрлэн таньж илэрхийлдэг гэсэн онолын үзэл баримтлалтай тохирч байгаа бөгөөд ийм метафорыг онтологи метафор /ontological metaphors/ гэж нэрлэсэн байна.

ДЭЛБЭРТЛЭЭ УУРЛАХ хэмээсэн хэллэгийн сурвалж ба бай хүрээний концептуал шинжүүд сэтгэлгээний орон-сүлжээнд хэрхэн нэгдэж багцарсныг G. Fauconnier & M. Turner нарын боловсруулсан 'Концептуаль интеграцийн онол'-оор [12:34] дүрслэн харуулбал дараах байдалтай болно. Үүнд:



Загвар 1. ДЭЛБЭРТЛЭЭ УУРЛАХ хэмээсэн хэллэгийг сэтгэлгээний орны нэгдлээр задалсан загвар.

Үүнд, хүний сэтгэлийн сөрөг хөдөлгөөн-уурлах, хилэгнэх үйлийн шинж байдлыг шингэн төлөвт бодисын халах, буцлах, дэврэх, дэлбэрэх физик шинжүүдтэй авалцуулан, концептуал байдлаар хийсвэрлэн сэтгэж, адил чанарт болгосон гэж үзнэ.

Сурвалж ба бай хүрээний хооронд нийтлэг орны шинжүүд нэвт үйлчилж, мэдээллийн орны сүлжээнд шинэ нэгдлийг үүсгэсэн нь угтаа бай хүрээн дэх концептуал бүтцийг бодит ертөнцийн танилт, туршлагаар сэтгэн ухаарч илэрхийлсний үр дүн болно. Дандины чимгийн шастирын ухаанаар бол үлгэрт хийгээд үлгэр, дүрслэгдэхүүн хийгээд дүрслэхүүн, адилтгагдахуун хийгээд адилтахууны "ямар мэт байгаа шинжүүд"-ийг сэтгэхүйн нарийн үйлдлээр холбон, 'тэгш онолт болгох' буюу адил ухагдахуун болгож байгаа хэрэг билээ.

Дээр дурдсан баримтаас дараах дүгнэлтийг хийж байна.

1. Метафор бол концептуал бүтэц бөгөөд домаинуудын хоорондох тохирлууд нь концептуал тогтолцоонд хэрэгждэг гэдгийг Монгол хэлний уурын концепт болон метафорын жишээ харуулж байна.
2. Ууртай хүн, ууртай сав (уур бүхий буюу уураар дүүрсэн) хоёр нь концептуал шинжээрээ яв цав тохирч байсны улмаас монгол хэлний УУР I(усны), УУР II (хилэн) нь омоними буюу дуудлага, бичлэгээрээ ижил үг болсон гэж үзэж болох бөгөөд монгол хэлний ижил үг үүсэх, ялангуяа, үг хорших ёсны учир холбогдлыг мэдлэгийн сүлжээг загварчлах буюу концептуал интеграцийн түвшинд судлууштай байна.
3. Метафор бол ард түмний оюун сэтгэлгээ, аж төрөхүйн ёс, ертөнцийг үзэх үзэл, ёс заншил, нийгэм-соёлын онцлогийг тусган илэрхийлсэн байдлаараа хэлний танин мэдэх бүтээлч чадварын илэрхийлэл гэдэг үзлийн үүднээс түүний сурвалж ба бай хүрээний "ямар мэт шинжүүд"-ийг концептуал анализын аргаар задлан тайлбарлаж, бодит ертөнцийг хэлээр сэтгэн ухаарч танин мэдэж буй байдал, үндэстний мэргэн ухаан, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг нээн харуулах боломжтой юм.
4. Монгол, Солонгос хэлэнд уурын метафор илэрхийллийн сурвалж хүрээ нь ерөнхийдөө адил төстэй байгаа нь уурын метафор бол хэл, соёлын нийтлэгийн шинжтэйг харуулж байна.
5. Когнитив утга судлалын орчин үеийн онолын үзэл санааг Зохист аялгууны толийн тайлбарт өгүүлсэн адилтгал зүйрлэлийн бэлгэ чанарыг гаргах арга ухаантай холбон үзвэл сонирхолтой санаа нэлээд байна.

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

- Бира, Ш. (1982). *Дандины Зохист аялгууны толь. /Dandin's 'Kāvyaḍarḗa' in Modern Mongolian and with Commentaries/*, Улаанбаатар
- Гаадан, Х. (1986). *Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл*. Улаанбаатар
- Им Жи Рён. (2002). Сүүрь сэтгэл хөдлөлийн адилтгалын хэв маягийн судалгаа
- Норжин, Ц. *Монгол хэлний толь*. Хөх хот
- Сэцэнцогт. (1988). *Монгол үгсийн язгуурын толь*, Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар
- Чулуундорж, Б. (2001). *Когниц: сэтгэл судлал-хэлшинжлэл-мэдлэгийн онол*. Улаанбаатар
- Kvecses, Z. (2000). The Concept of Anger: Universal or Culture Specific?. *Psychopathology*, 33, 159-170.
- Kvecses, Z. (2005). *Metaphor in culture: universality and variation*. Cambridge: Cambridge University Press.
- Vyuyan Evans., Melanie Green. (2006). *Cognitive Linguistics. An Introduction*. Edinburgh University Press.
- Vyuyan Evans.(2007). *A Glossary of Cognitive Linguistics*. Edinburgh University Press.
- William Croft., Alan D. Cruse. (2010). *Cognitive Linguistics*. VI printing. Cambridge University Press.
- Попова. З. Д., Стернин. И. А. (2007). *Когнитивная лингвистика*. Москва